



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 08 өдөр

Дугаар А/106

Бөхт


Засаг даргын нөөцөөс хөрөнгө зарцуулах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц сангийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6, сумын Засаг даргын зөвлөлийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 08 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагаа-6” аяны хүрээнд зохион байгуулагдсан спорт, хууль эрх зүйн алтан хонх, эх хэлний тэмцээнүүдэд амжилттай оролцсон багуудын шагналд 1,900,000 (нэг сая есөн зуун мянга) төгрөг, өргөмжлөл, батламжийн үнэ 269,500 (хоёр зуун жаран есөн мянга таван зуун) төгрөг, 2023 оны ажлын дүнгээр сумын төрийн албан хаагчдаа манлайлан ажиллаж “Манлайлагч төрийн албан хаагч”-аар шалгарсан Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга Д.Уранбилэг, Ерөнхий боловсролын сургуулийн захирал Н.Дэлгэрсайхан, Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Номин-Эрдэнэ нарт 900,000 (есөн зуун мянган) төгрөг, нийт 3,069,500 (гурван сая жаран есөн мянга таван зуун) төгрөгийн зарцуулсугай.

2.Дээрх зардлыг Засаг даргын нөөц хөрөнгийн Хүний нөөцийг хөгжүүлэх дэд хөтөлбөрийн санхүүжилтийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Амгаланжаргал)-д, холбогдох санхүүгийн баримтыг бүрдүүлэхийг нярав (Т.Батбилэг) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



У.АЛТАНХҮҮ